

Монгол судлаач нэрт эрдэмтэд Л. М. Гатауллина, С. Д. Дылыков, И. С. Казакевич, С. К. Рошин, Г. С. Матвеева (хариуцлагатай редактор) нар эрхэлж олон тооны монгол судлаачид оролцон бүтээсэн энэхүү лавлах нь баялаг агуулга ба хэмжээний хувьд тус улсын талаар урьд өмнө хэвлэгдэн гарсан аль ч лавлахаас илүү чамбай, ялангуяа улс орны амьдралын бүхий л талыг багтаасан учир ямарч мэргэжлийн хүн ашиглаж болох шинжилгээ судалгааны болон практик ач холбогдолтой төдийгүй манай улсын талаар сонирхох гадаадын уншигчид, монгол судлаачдад гарын авлага болох үнэт шинэ бүтээл болсон нь дамжиггүй.

### Э. Пунцаг

#### **«ЭРГЭЖ ИРЭХГҮЙ НОМОНХАН НОМЫН ТУХАЙ**

К. ИШИДА, «Кайразару Номонхан»  
(Токио, 1985, х. 253)

К. Ишида\*-гийн бичсэн «Эргэж ирэхгүй Номонхан» хэмээх номыг 1985 оны 9-р сарын 15-нд Японд хэвлэн гаргажээ. Энэхүү 18 бүлэг, 93 зүйл, 3 хавсралт, 253 талтай номыг Халх голын районд Японы милитаристуудыг бутцохисны 45 жилийн ойн босгон дээр гаргасан нь тохиолдлын бус зүйл гэдэг нь ойлгомжтой. Уг номонд олон төрлийн фото зураг, газрын зураг оруулж дурдатгал маягаар бичжээ.

Нэг талаас Халх голын районд болсон дайныг «хилийн будлиан», «орон нутгийн чанартай» дайн гэж үзэн түүхэн байдлыг гуйвуулж, нөгөө талаас Японы ард түмэнд уг дайныг Японы милитаристууд бус, харин монгол цэргүүд «хил зөрчин» өдөөн гаргасан мэтээр ойлгуулахыг оролдох, ингэснээрээ Японд милитарист үзэл санааг сэргээн дэвэргэх явдалд тойруу замаар дэмжлэг үзүүлэх утга агуулга бүхий ном зохиол Японд гарсаар байна. Ийм санаа Ишидагийн номд ч орхигдсонгүй.

Японы түүх бичлэгт Халх голын дайныг «Номонханы хэрэг явдал» гэж нэрлэдэг бөгөөд Халх голын эргийн ойролцоо, Хайлааст голоос хойш оршдог газрыг уг номонд «Хоёр толгойн дундах гурвалжин хэл бэрийн нам дор газар нь Номанхан болно» (86-р тал) гээд дайн үүсэх, шалтгааныг бичихдээ: «1939 оны 1-р сарын 17-нд гадаад Монголын хилийн цэргүүд Номонханы Манжийн талын хилийн харуулруу дайрснаар хэрэг явдал эхэлж (20-р тал), улмаар өдөөн хатгасан шинж чанартай болж өөрчлөгдсөн» гэжээ. Тэгвэл К. Яно тэргүүтэй групп Японы Квантуны армийн жанжин штабын даргын онцгой даалгавраар 1938 оны намар 2 сарын турш Дотоод Монголын хилийн районы ойролцоо (Халх голын сав газар. — ) хийсэн шинжилгээ судалгааны гол зорилго нь: манай улсын хилийн район дахь цэргийн чухал газруудыг судлах, хилийн байдал болон харуул хамгаалалтыг нягтлан хил орчмын ард олны

\*. Зохиогч нь 1902 онд төрсөн. Японы урлагийн дээд сургуулийн орос хэлний факультетэд суралцаж байгаад дараа нь ЗХУ-ын Москвагийн бүх холбоотын урлагийн академид судалгааны ажил хийв. 1936 онд «Мантэцу» (Манжуурын төмөр замын дэргэдэх судалгааны газар)-д ажилд оржээ. 1940 оны 9-р сард хил тогтоохоор хийсэн хэлэлцээрт нарийн бичгийн дарга, орчуулагчаар оролцсон. Дайны дараа Японы парламентын номын санд ажиллаж БНМАУ «Монгол-Орос-Япон хэлний дэлгэрэнгүй толь» «Чайковский» зэрэг ном бичжээ.

шилжилт, хөдөлгөөнийг ажиглан мэдэх явдал байсан (221-р тал) зэргээс үзэхэд Япон-Манжийн тал БНМАУ-д халдан довтолж түрэмгий төлөвлөгөөгөө нилээд эртнээс, нарийн бэлтгэлтэй хийж байсныг нь нотолж байна. Энэ бэлтгэлийнхээ үндсэн дээр өдөөн хатгах ажиллагаагаа улам хүчтэй болгож, 1939 оны 1-р сараас БНМАУ-ын хилийг дахин зөрчиж, улмаар 5-р сарын 11-нд Халх голын орчмоор халдан довтолсон юм.

Зохиогч номынхоо гарчгаас эхлээд «хэрэг явдал», «хилийн будлиан» гэх мэт хямдхан цагаан цайвар нэр зүүсэн боловч Халх голын дайн хэрэг дээрээ орчин үеийн томоохон дайн байсан гэдгийг зохиогчийн иш татсан баримт сэлт бэлхнээ нотолж байна.

Номондоо «Газар дорх бэхлэлт», «Хээрийн эмнэлгийн ул мөр», «Цэргүүдийн хүүр ба хүний ясан уул» гэсэн гарчгууд тавьж, «Өдөр бүр шөнө дөл болтол гэрлээ унтраасан галт тэрэгний цуваа шархдагсдыг зөөн тасралтгүй ирж байсны улмаас Харбин хотын хуурай замын цэргийн эмнэлэг шархдагсдаар пиг дүүрсэн» (17-р тал), «Элсэн дээр цайран харагдах хүний ясан уул сэтгэлээс хэзээч гарахгүй хар сүүдэр болон үлдсэн» (98-р тал) тухай бичиж зохиогч урьд болон одоо болж байгаа сэтгэлийн хямралаа дүрсэлсэн зэргээс үзэхэд ч хир зэрэг томоохон дайн байсан нь илэрхий.

К. Ишида 1939 оны 1-р сараас 8-р сар хүртэлх хугацааны тулалдааны байдлыг эс хөндөн мөн оны 8-р сарын дунд үе гэхэд ширүүн тулалдаан дээд цэгтээ хүрсэн тухай өгүүлжээ. Гэтэл номын 88-р талд 1939 оны 1-р сараас үргэлжилсэн хилийн мөргөлдөөн 5, 6-р сар гэхэд замын дундаас нь таслан зогсоох аргагүй будлиан болон өргөжсөн тул дэслэгч генерал Комацубарагийн 23-р дивиз тулалдаанд орсон мэт бичсэн нь Японы милитаристуудын түрэмгий үйл ажиллагааг хаацайлж цагаатгах гэсэн оролдлого гэж үзүүштэй.

«Манж, Монгол хоёр улсын нүүр царайны цаана Япон, Зөвлөлт хоёрын үнэн дүр төрх илэрхий болсон» (21-р тал) гэсэн мөрнөөс харахад чуг «хэрэг явдал» нь бүр хоёр системийн хоорондох томоохон дайн байсан гэдгийг зохиогч хүлээн зөвшөөрч байгаа нь илэрхий. Жишээлбэл Халх голын дайн бол үлэмж хэмжээний цэрэг, зэвсэг, техник оролцсон орчин үеийн дайн байсныг зөвхөн японы талаас гэхэд л Квантуны армийн шилдэг ангиудыг дайчилж 75 мянга шахам цэрэг, 500 гаруй их буу, 180 танк, 300-350 нисэх онгоц оролцсон явдал гэрчилж байна.

Зохиогч «Энэ удаад (Номонханы хэрэг явдлыг хэлээ. --Н. Б) оролцохынхоо өмнө Квантуны арми нь Ганчаазү-ийн (1937 оны 6-р сар) болон Хасан нуурын орчим дахь (1938 оны 7-р сар) хэрэг явдлын түүхэн сургамжийг санах хэрэгтэй байсан юм» (21-р тал) хэмээн хожимдсон гэмшлээ илэрхийлсэн ч номынхоо төгсгөлд «...хилийн талаарх нийтлэг ойлголтыг дахин бодож үзэхдээ хайран залуу амиа харийн нутагт алдсан олон арван баатарлаг элэг нэгтнийхээ дурсгалыг мартажгүй байвал энэ номын хэрэг бүтнэ» гэсэн нь хонзогнох үзэл санааг хөхүүлэн дэвэргэгч Японы судлаачдын зөвхөн зарим хэсэг, тухайлбал түүний нэг төлөөлөгч К. Ишида-гийн үзэл болохоос биш Халх голын дайны үнэн түүх, түүнийг хэрхэн дүгнэх тухай асуудлаарх Японы ард түмний нийтлэг үзэл биш гэдэгт эргэлзэх зүйлгүй.

**Н. Бадамханд**

\*. МАХН-ын товч түүх. УБ, 1985, 191-р тал